



**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН
СУРГАЛТ ХӨТӨЛБӨР**

БОЛОВСРОЛЫН ГАЗАР-2021 он

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/34

Чойр

Албан хаагчдын сургалтын хөтөлбөр
батлах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, 38 дугаар зүйлийн 38.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Боловсрол, соёл урлагийн газрын албан хаагчдын сургалтын хөтөлбөрийг 1 дүгээр, сургалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгахыг Төсвийн мэргэжилтэн ба нягтлан бодогч (О.Дөлгөөн)-д зөвшөөрсүгэй.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ахлах мэргэжилтэн (С.Энх-Амгалан)-даалгасугай.

ДАРГА



А.ЗУРГААНЖИН

“ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ” ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Хөтөлбөр боловсруулах үндэслэл:

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3-т “Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.” гэж заасан ньэнэхүү хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл ньболно.

Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага:

Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл ньтөрийн захиргааны бүх шатны байгууллага зорилт, чиг үүргээ мэдлэг чадвартай хүний нөөцийн хүчээр хэрэгжүүлэх, иргэдэд чанартай төрийн үйлчилгээ үзүүлэх шинэ шаардлага, хариуцлагын шинэ тогтолцоог бий болгохыг шаардаж байна.Энэ нь төрийн албыг явуулахад шинэ мэдлэг чадварыг шаардаж байна. Төрийн албан хаагчийн ажил үүргийг дүгнэх, урамшуулах, шагнахад чадахуйн зарчмыг үндэслэл болгохоор зохицуулагдсан төдийгүй төрийн албан хаагчийн тусгай хөтөлбөрөөр тогтмол сургах шинэ зохицуулалт үйлчилж эхэлсэн. Төрийн албан шинэчлэлийн хүрээнд:

- ✓ Төрийн шинэчлэл-хууль журмыг шинэчилсэн.
- ✓ Төрийн албан хаагч шинэчлэлийн сэтгэлгээтэй болох шаардлага үүссэн.
- ✓ Албан тушаалын тодорхойлолт бүрэн шинэчлэгдсэн. Албан тушаалын тодорхойлолт нь шагнах, урамшуулах, хариуцлага тооцох, сургалтанд хамруулах үндэслэл болох тул ур чадварын шаардлагуудыг бүрэн эзэмшихийн тулд ажлын байранд тогтмол суралцах
- ✓ Чадвартай, мэдлэгтэй, мэргэшсэн тогтвортой төрийн албыг бүрдүүлэх зорилт тавьсан.
- ✓ Үндэсний язгуур эрх ашгийн төлөө, хуулийг чанд баримталдаг, иргэдэд үйлчилдэг байх ёстой
- ✓ Мэргэшсэн, чадахуйн зарчмыг бий болгосон.

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд ахиц, өөрчлөлт гарч уул уурхай, төмөр зам, хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчин, эрчим хүч, эрүүл мэнд, боловсрол гээд эдийн засаг, нийгмийн чухал салбарууд эрчимтэй хөгжиж байна. Үүнийг дагаад төрийн үйлчилгээний шинэ шинэ хэлбэрүүд бий болж, түүнд хамрагдах иргэдийн тоо нэмэгдэж байгаа энэ үед төрийн байгууллага боловсон хүчнээ чадваржуулах, шинэ мэдлэг, боловсрол олгох, мэргэшүүлэх ажлыг шинэ шатанд гаргах зайлшгүй шаардлага гарч байгаа юм.

Хоёр. Хөтөлбөрийн ерөнхий зорилго

Хөтөлбөрийн зорилго нь Монгол улсын Үндсэн хууль, үндэсний язгуур ашиг сонирхолд нийцсэн, иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэсэн, тэдэнд ойр, өөрчлөгдөж буй нөхцөл байдалд уян хатан ханддаг, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн, идэвхитэй, санаачилгатай бөгөөд манлайлагч менежер, мэдлэг чадвартай албан хаагч бүхий төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн зорилт, түүнийг хэрэгжүүлэх зарчим

Төрийн албан хаагчийг ажлын байранд нь сургах, өөр байгууллага, хамт олноос суралцах боломж бүрдүүлэх буюу богино хугацааны зорилтот сургалтаар давтан сургах, боловсролын мэргэжлийн байгууллагад суралцуулах, тодорхой сэдэв эсвэл мэргэжлээрээ дагнан суралцах хүрээнд зохион байгуулна.

1. Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд албан хаагчдын практик ур чадварыг сайжруулах, албан хаагч нэг бүрийг ажлын байранд нь сургах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
2. Шинэ албан тушаалд томилогдсон, албан тушаалын ангилал, зэрэглэл ахисан, өөр ажилд шилжсэн үед тухайн албан тушаалын онцлог, тавигдах шаардлагад нийцүүлэх сургалтад хамруулж байх. Тухайн байгууллага энэ чиглэлээр сургалт явуулах байнгын төлөвлөгөөтэй байна. Уг төлөвлөгөөндөө
 - а/ мэдлэг, туршлагатай ажилтныг дагалдуулж сургах
 - б/ өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөртэй ажиллуулах
 - г /ажил, албан тушаал сэлгэн ажиллуулах талаар тусгасан байх;
3. Оны сүүлчийн улиралд дараа жилийнхээ сургалтын хэрэгцээгээ тодорхойлох, төлөвлөх ажлыг зохион байгуулна. Үүний тулд хамт олны дунд ярилцлага хийх, судалгаа авах, байгууллага, ажлын байрны шинжилгээ, албан тушаалын тодорхойлолт, ажлын үзүүлэлт зэргийг харгалзан үзнэ. Мөн мэргэжлийн байгууллага, сургалтын багш мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах;
4. Шинэ залуу ажилтнуудыг мэдлэг, туршлагатай ажилтныг дагалдуулж сургах, өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөө, хөтөлбөртэй ажиллуулах, туршилтын хугацаанд хийх ажил, үүргийг нь тодорхой болгон ажиллана;
5. Ажилтны онцгой ур чадвар, ажлын туршлагад тулгуурлан тодорхой хугацаа, тодорхой сэдвээр шинэ зүйлийг боловсруулахаар томилон ажиллуулах, туршилт, судалгаа хийлгэх;
6. Ажилтан бүр чиг үүрэг, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ өөрийн хүч, авьяас, мэдлэг чадвараа дайчлан ажиллахын зэрэгцээ шинэ санаа, шинэ арга барилд суралцах, мэдээлэл хайж олж авах, туршилт хийх, шийдэлд хүрэх ба шинээр олсон зүйлээ баг, хамт олондоо мэдээлэх, хуваалцах;
7. Мэдлэг, мэдээлэл хуваалцахыг ажлын хэвшмэл хэсэг болгож, аливаа асуудлыг багаар ажиллах зарчмаар оновчтой шийдэлд хүрэх арга барилд сургах, үүний тулд тухайн хамт олны дунд багаар шийдвэрлэх асуудлыг урьдчилан төлөвлөсөн байх;
8. Албан тушаалтан бүр өөрийн хариуцсан ажил, үүргийнхээ чиглэлээр сургалтын материал, гарын авлага, ном товхимол гарган бусдын хүртээл болгох;
9. Аймгийн ЗДТГ болон мэргэжлийн бусад байгууллагуудтай хамтарсан буюу бие даасан сургалт, семинарыг зохион байгуулахаар жилийн төлөвлөгөөндөө тусгаж ажиллах;
10. Гадаадад явж суралцсан буюу туршлага судлах хөтөлбөрт хамрагдсан албан хаагч бүр үзсэн, сурсан бүхнээ хамт олон, бусдад мэдээлэх, уулзалт ярилцлага хийх, сургалт зохион байгуулж хэвших, гарын авлага, заавар зөвлөмж гаргах;
11. Өөраймаг, сумын туршлагаас болон ахмад ажилтнаас тогтмол суралцах
12. Төрийн албан аагчдыг гадаад, дотоодын сургуулиудад сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, удирдах ажилтны нөөц бүрдүүлэх, ирээдүйн шинэ залуу боловсон хүчнийг сургах, бэлтгэх ажлыг хамтран зохион байгуулна.
13. Боловсон хүчнийг гадаад, дотоодод сургах, мэргэшүүлэх хэрэгцээ, шаардлагыг урьдчилан судлах, төлөвлөх, сургалтад хамрагдсаны дараа хамтран ажиллах зэрэг үүргийг байгууллагын хүний нөөц хариуцсан албан тушаалтан хариуцах, удирдлагад танилцуулж байх;

14. Хүний нөөцийн төлөвлөгөө, судалгаа, албан тушаалтны гүйцэтгэлийн чадвар зэргийг үндэслэн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудыг мэргэжлийнх нь дагуу буюу ерөнхий мэдлэгийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтад дэс дараатайгаар хамруулна;
15. Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөний дагуу төрийн болон нийгмийн удирдлагын мэргэшүүлэх, менежер, магистр бэлтгэх сургалтад хамруулах;
16. Аймаг, орон нутгийн хэмжээнд салбарын чиглэлээрх нэн чухал шаардлагатай, дутагдалтай мэргэжлийн судалгаа гаргаж тэдгээр мэргэжлээр суралцаж буй оюутнуудтай холбогдож ажиллах
17. Төрийн албан хаагчдыг тодорхой сэдвээр мэргэших, эрдмийн цол зэрэг хамгаалах, бие даан бүтээл туурьвих зэрэг үйл ажиллагааг дэмжих
18. Эрдмийн ажил, сорил туршилт хийх, судалгаа шинжилгээ явуулах талаар эрдэмтдийн мэргэжлийн зөвлөл, багш, удирдагчдыг урьж сургалт семинар хийлгэх, ярилцлага, зөвлөгөө өгүүлэх, элсэлт зохион байгуулах зэргээр дэмжлэг туслалцаа үзүүлэх;

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

1. Хөтөлбөрийг 2021-2024 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ.
 - a. Улсын төсвийн хөрөнгө
 - b. Орон нутгийн төсвийн хөрөнгө
 - c. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө
 - d. Хандив, тусламж

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хүний нөөц, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллана.
2. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан албан тушаалтан эрхлэн гүйцэтгэнэ.
3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор дүгнэнэ.
4. Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтээр гаргана:
 - a. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиож буй ажил, судалгаа, төлөвлөгөө, үр дүнгээр;
 - b. Байгууллагаас сургалтад хамрагдсан нийт төрийн албан хаагчдын тоо /давхардсан байдлаар/;
 - c. Суралцагч байгууллага болох талаар хийж хэвшүүлсэн ажил, түүний үр дүнгээр;
 - d. Шинээр ажилд орсон болон шинэ залуу ажилтнуудыг оролцуулан зохиож буй ажил;
 - e. Ажилтнуудынхаа мэдлэг боловсрол, ур чадвар, ажлын туршлагыг нь хэрхэн яаж дүгнэж, ашиглаж байгаа байдал;
 - f. Тухайн байгууллагад нэвтэрсэн шинэ санаа, дэвшилтэд арга барил, ажлын туршлага;
 - g. Багаар шийдвэрлэсэн ажил, түүний үр дүн;
 - h. Төрөлжсөн болон нэгдсэн сургалт, семинарын үр дүн, дэвшүүлсэн зорилт, сургалтын хөтөлбөр, гарсан үр дүн
 - i. Гадаад, дотоодын сургууль, курст хамрагдсан ажилтны тоо;
5. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хамаарах хууль, тогтоомж, дүрэм, журам өөрчлөгдсөн тохиолдол бүрт нэмэлт өөрчлөлт, тайлбар, тодруулга хийх бөгөөд хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Зургаа. Хөтөлбөрийн үр дүн

“Төрийн албан хаагчийн сургалт” хөтөлбөр хэрэгжсэнээр:

1. Төрийн албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх ажил тогтмолжиж сайжирна;
2. Төрийн албаны тухай болон бусад хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдана;
3. Суралцагч байгууллага болсон байна;
4. Төрийн албан хаагч бүр мэдлэг, чадвартай болж, түүнийгээ хөгжүүлэх, албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх чадвар, чадамжтай болсон байна.
5. Төрийн үйлчилгээний чанар, үр ашиг, үр нөлөө сайжирсан байна.